# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ГСА-2021/45/СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот

2021 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Аудитор:Б.Анхтуяа

Утас:70543179

Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| АИТХ | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| БСШУЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 14

3. Аудитын тайлан ..... 15

3.1. Ерөнхий зүйл ..... 15

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 15

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 15

3.4. Материаллаг байдал ..... 16

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 16

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 17

3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 18

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18

3.9. Аудитын илрүүлэлт ..... 19

Залруулсан алдаа ..... 19

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 20

Аудитын зөвлөмж ..... 21

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 21

4. Менежментийн захидал ..... 22

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 23

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2021·02·22 № 16

танай ____________-ны № ____________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
А.ЗУРГААНЖИН ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл урлагийн газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл урлагийн газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 109 арга хэмжээ төлөвлөж бүрэн хэрэгжүүлж ажилласан ба аймгийн ТЕЗ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 85.1%-тай дүгнэсэн байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

008020021

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,976,478.75** | **10,914,248.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 832,500.00 | 582,750.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 832,500.00 | 00.00 |
| 31110 | Төгрөг | 832,500.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 582,750.00 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 582,750.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 582,750.00 |
| **33** | **АВЛАГА** | 21,270,728.75 | 801,500.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 258,159.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 801,500.00 |
| **335** | **Бусад авлага** | 21,012,569.75 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 657,569.75 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 20,355,000.00 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 350.00 | 00.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 350.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 7,872,900.00 | 9,529,998.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,872,900.00 | 9,529,998.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,027,500.00 | 1,248,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,462,600.00 | 3,502,700.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 580,000.00 | 758,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 640,000.00 | 640,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,162,800.00 | 3,380,398.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **121,456,318.97** | **160,130,710.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 121,456,318.97 | 160,130,710.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 39,624,318.97 | 104,454,910.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 28,164,100.00 | 28,164,100.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -469,401.72 | -938,803.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,221,075.00 | 69,821,075.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -36,221,075.00 | -39,487,741.69 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,184,104.83 | 74,848,216.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -73,057,784.13 | -38,303,822.66 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,609,535.51 | 24,282,235.51 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,806,235.52 | -13,930,348.06 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,544,367.20 | 1,544,367.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,544,367.20 | -1,544,367.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 81,832,000.00 | 55,675,800.04 |
| 39301 | Програм хангамж | 3,040,000.00 | 3,040,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,740,000.00 | -2,064,999.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 80,532,000.00 | 58,608,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -3,907,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **151,432,797.72** | **171,044,958.98** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,916,030.79** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,916,030.79 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 1,916,030.79 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 252,018.79 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,664,012.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,523,298.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 140,714.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **149,516,766.93** | **171,044,958.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 149,516,766.93 | 171,044,958.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 251,766,128.90 | 251,766,128.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 251,766,128.90 | 251,766,128.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -125,348,984.06 | -103,820,792.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -125,348,984.06 | -125,180,207.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 21,359,415.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 23,099,622.09 | 23,099,622.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **151,432,797.72** | **171,044,958.98** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **674,899,864.45** | **639,881,503.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,443,200.00** | **102,642,803.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,443,200.00 | 102,642,803.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,443,200.00 | 101,199,603.66 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,443,200.00 | 3,350,350.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 97,849,253.66 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 1,443,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **673,456,664.45** | **537,238,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 455,218,000.00 | 145,847,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 455,218,000.00 | 145,847,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 217,406,164.45 | 10,848,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 217,406,164.45 | 10,848,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 832,500.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 832,500.00 | 380,542,900.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 380,542,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **645,819,740.60** | **594,012,724.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **645,819,740.60** | **594,012,724.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 367,006,924.54 | 191,540,583.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 117,308,706.00 | 112,828,561.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 115,745,268.00 | 112,828,561.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,563,438.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,350,344.99 | 15,219,472.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,396,177.99 | 10,778,250.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 588,093.00 | 907,069.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 355,642.00 | 1,091,424.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 708,389.00 | 222,062.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,302,043.00 | 2,220,667.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,698,106.00 | 4,590,410.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 340,906.00 | 326,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,865,670.00 | 1,915,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 223,530.00 | 269,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,268,000.00 | 2,079,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,995,106.20 | 25,411,592.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,933,297.00 | 1,856,079.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,703,200.00 | 3,068,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 299,722.50 | 339,771.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,227.50 | 11,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,258,550.00 | 1,709,340.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,788,109.20 | 00.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 18,426,302.66 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 795,100.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 795,100.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,992,000.00 | 207,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,992,000.00 | 207,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,908,950.00 | 2,962,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,908,950.00 | 2,148,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 148,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 143,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 22,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 199,958,611.35 | 30,320,847.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 193,443,821.40 | 11,554,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 967,925.00 | 1,301,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,546,864.95 | 17,464,797.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 278,812,816.06 | 402,472,141.27 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 272,805,174.00 | 387,266,193.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 958,522.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 140,993,400.00 | 220,275,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 130,853,252.00 | 164,822,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 2,168,193.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,007,642.06 | 15,205,948.27 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 15,012,498.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,007,642.06 | 193,450.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **29,080,123.85** | **45,868,778.84** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 24,509,363.68 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 24,509,363.68 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -24,509,363.68 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **29,080,123.85** | **21,359,415.16** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **674,899,864.45** | **542,032,250.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,443,200.00** | **4,793,550.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,443,200.00 | 4,793,550.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,443,200.00 | 3,350,350.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,443,200.00 | 3,350,350.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 1,443,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **673,456,664.45** | **537,238,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 455,218,000.00 | 145,847,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 455,218,000.00 | 145,847,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 217,406,164.45 | 10,848,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 217,406,164.45 | 10,848,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 832,500.00 | 00.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 832,500.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 380,542,900.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 380,542,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **666,067,364.45** | **540,838,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **666,067,364.45** | **540,838,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **362,480,548.39** | **157,920,158.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 118,095,299.99 | 113,028,987.32 |
| 210101 | Үндсэн цалин | 98,022,199.99 | 87,173,196.89 |
| 210102 | Нэмэгдэл | 13,101,456.00 | 17,330,880.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,948,866.00 | 7,194,710.00 |
| 210104 | Урамшуулал | 1,022,778.00 | 1,330,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,705,100.00 | 15,017,721.41 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,864,200.00 | 10,601,352.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 960,200.00 | 1,104,127.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 784,200.00 | 883,322.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 176,000.00 | 220,265.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,920,500.00 | 2,208,653.29 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,698,106.00 | 4,590,410.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 340,906.00 | 326,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,548,400.00 | 1,915,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 540,800.00 | 80,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,268,000.00 | 2,268,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,938,900.00 | 6,298,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,240,000.00 | 1,056,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 3,068,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 358,722.50 | 622,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 211,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,000.00 | 370,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 470,177.50 | 968,490.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,329,200.00 | 00.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,329,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,992,000.00 | 207,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,992,000.00 | 207,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 103,179,100.00 | 3,280,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 103,179,100.00 | 1,941,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 148,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 143,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 124,700.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 401,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 109,542,842.40 | 15,497,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,842,842.40 | 12,715,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,700,000.00 | 2,782,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **303,586,816.06** | **382,918,641.27** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 293,160,174.00 | 366,911,193.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 958,522.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 161,359,400.00 | 199,920,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 130,842,252.00 | 164,822,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 2,168,193.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,426,642.06 | 16,007,448.27 |

| | | | |
|---|---|---|---|
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 15,012,498.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,426,642.06 | 994,950.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,832,500.00** | **1,193,450.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,000,000.00** | **1,443,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,000,000.00** | **1,443,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,000,000.00 | 1,443,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,000,000.00 | 1,443,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,000,000.00** | **-1,443,200.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 832,500.00 | -249,750.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 832,500.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 832,500.00 | 582,750.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 171,234,128.90 | 2,585,522.09 | -114,194,528.43 | 00.00 | 59,625,122.56 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **171,234,128.90** | **2,585,522.09** | **-114,194,528.43** | **00.00** | 59,625,122.56 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 48,822,124.34 | 00.00 | 48,822,124.34 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **251,766,128.90** | **23,099,622.09** | **-125,348,984.06** | **00.00** | 149,516,766.93 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **251,766,128.90** | **23,099,622.09** | **-125,348,984.06** | **00.00** | 149,516,766.93 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 168,776.89 | 00.00 | 168,776.89 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **251,766,128.90** | **23,099,622.09** | **-125,180,207.17** | **00.00** | 149,685,543.82 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 21,359,415.16 | 00.00 | 21,359,415.16 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **251,766,128.90** | **23,099,622.09** | **-103,820,792.01** | **00.00** | 171,044,958.98 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 455,218,000.00 | 450,322,579.99 | 526,535,600.00 | 511,377,901.73 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 455,218,000.00 | 450,332,579.99 | 526,535,600.00 | 511,377,901.73 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 158,830,700.00 | 157,172,405.99 | 145,992,700.00 | 144,466,708.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 118,095,300.00 | 118,095,299.99 | 113,315,400.00 | 113,028,987.32 |
| 210101 | Үндсэн цалин | 98,022,200.00 | 98,022,199.99 | 90,871,300.00 | 87,173,196.89 |
| 210102 | Нэмэгдэл | 11,523,400.00 | 13,101,456.00 | 13,894,400.00 | 17,330,880.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,776,000.00 | 5,948,866.00 | 6,776,000.00 | 7,194,710.00 |
| 210104 | Урамшуулал | 1,773,700.00 | 1,022,778.00 | 1,773,700.00 | 1,330,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,705,100.00 | 14,705,100.00 | 16,192,700.00 | 15,017,721.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,864,200.00 | 10,864,200.00 | 12,094,200.00 | 10,601,352.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 960,200.00 | 960,200.00 | 1,024,600.00 | 1,104,127.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 768,200.00 | 784,200.00 | 819,700.00 | 883,322.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 192,000.00 | 176,000.00 | 204,900.00 | 220,265.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,920,500.00 | 1,920,500.00 | 2,049,300.00 | 2,208,653.29 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,702,200.00 | 4,695,106.00 | 4,590,600.00 | 4,590,410.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 348,000.00 | 340,906.00 | 326,700.00 | 326,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,548,400.00 | 1,548,400.00 | 1,915,900.00 | 1,915,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 537,800.00 | 537,800.00 | 80,000.00 | 80,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,268,000.00 | 2,268,000.00 | 2,268,000.00 | 2,268,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,938,900.00 | 5,938,900.00 | 6,306,800.00 | 6,298,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,240,000.00 | 1,240,000.00 | 1,056,500.00 | 1,056,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 3,500,000.00 | 3,068,500.00 | 3,068,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 328,900.00 | 358,722.50 | 622,600.00 | 622,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 300,000.00 | 211,500.00 | 211,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, | 70,000.00 | 70,000.00 | 370,800.00 | 370,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 470,177.50 | 976,900.00 | 968,490.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,329,200.00 | 2,000,000.00 | 00.00 | 00.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,329,200.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | 00.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,200,000.00 | 2,992,000.00 | 207,000.00 | 207,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,200,000.00 | 2,992,000.00 | 207,000.00 | 207,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,360,000.00 | 3,349,000.00 | 2,314,000.00 | 2,263,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,360,000.00 | 3,349,000.00 | 924,000.00 | 924,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 148,100.00 | 148,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 156,800.00 | 143,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 00.00 | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 148,400.00 | 124,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 00.00 | 11,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 00.00 | 403,700.00 | 401,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5500000.00 | 5397000.00 | 3066200.00 | 3060700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 425,669.00 | 278,700.00 | 278,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 4,971,331.00 | 2,787,500.00 | 2,782,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 296387300.00 | 293160174.00 | 380542900.00 | 366911193.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 296,387,300.00 | 293,160,174.00 | 380,542,900.00 | 366,911,193.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 161,359,400.00 | 161,359,400.00 | 213,010,300.00 | 199,920,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 134,027,900.00 | 130,842,252.00 | 165,222,600.00 | 164,822,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 958,522.00 | 2,310,000.00 | 2,168,193.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 455,218,000.00 | 450,322,579.99 | 526,535,600.00 | 511,377,901.73 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 455,218,000.00 | 450,322,579.99 | 526,535,600.00 | 511,377,901.73 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 455,218,000.00 | 450,322,579.99 | 526,535,600.00 | 511,377,901.73 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **00.00** | 00.00 | 832,500.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **832,500.00** | 00.00 | 582,750.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 08.00 | 08.00 | 08.00 | 08.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 06.00 | 06.00 | 06.00 | 06.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **212,694,442.40** | **9,853,350.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **212,694,442.40** | **9,853,350.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 212,694,442.40 | 9,853,350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 99,819,100.00 | 1,017,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 99,819,100.00 | 1,017,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 112,875,342.40 | 8836350.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,875,342.40 | 8,836,350.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 211,861,942.40 | 9853350.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 211,861,942.40 | 9,853,350.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 211,861,942.40 | 9,853,350.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 832,500.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч А.Зургаанжин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр тулгах, нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрх нээлгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-нээс 2021 оны 02 дугаар сарын 03-ны хооронд "Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар"-ын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар" 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар"-т 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Боловсрол, соёлын байгууллага, иргэдийг төрийн захиргаа болон мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, салбарын хөгжлийн бодлогыг эрхлэн хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын нягтлан бодогч Н.Одонтуяагийн хүүхэд асрах чөлөө дуусгавар болж, 2020 оны 09 дүгээр сарын 01-нд ажилдаа орсон байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар" нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь "Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл,

урлагийн газар"-ын санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 03 дугаар улирлын орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 438,666.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,386.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 598,267.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,981.7 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,612.1 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 832.5 | 582.8 | -249.7 |
| Авлага | 21,270.7 | 801.5 | -20,469.2 |
| Урьдчилгаа | 0.35 | 0.0 | -0.35 |
| Бараа материал | 7,872.9 | 9,529.9 | 1,657.0 |
| Үндсэн хөрөнгө | 121,456.3 | 160,130.7 | 38,674.4 |
| **Нийт хөрөнгө** | **151,432.8** | **171,044.9** | **19,612.1** |
| Өр төлбөр | 1,916.0 | 0.0 | -1,916.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 149,516.8 | 171,044.9 | 21,528.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **151,432.8** | **171,044.9** | **19,612.1** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 582.8 мянган төгрөг болж 249.7 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн төрийн сан дахь аймгийн ахмадын сангийн нэгдсэн данснаас байгууллага бүрд данс нээж буцаан олгосноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 801.5 мянган төгрөг болж 20,469.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн тэтгэмжийн авлага барагдаж, он удаан жил болсон бичилтийн алдаанаас болж үүссэн авлагыг хаасныас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд зарцуулж амжаагүй төвлөрүүлсэн хүүхэд харах үйлчилгээний 801.5 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,529.9 мянган төгрөг болж 1,657.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,657.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 160,130.7 мянган төгрөг болж 38,674.4 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 38,328.8 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 40,876.5 мянга, урсгал төсвийн худалдан авалтаар 1,443.2 мянга, нийт 80,648.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, АИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 21 дүгээр тогтоолоор үнэ төлбөргүй шилжүүлсэн 38,092.4 мянга, АИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 83 дугаар тогтоолоор акталсан 29,543.3 мянга, нийт 67,635.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн данс 21,924.0 мянган төгрөгөөр буурсан нь АИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 21 дүгээр тогтоолоор Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгт газар шилжүүлснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,916.0 мянган төгрөгөөр буурсан нь өр төлбөр барагдуулах ажлын хэсэг томилон, ажлын хэсгийн эзэн холбогдогч тодорхойгүй, дансны бичилтийн алдаанаас үүссэн талаарх дүгнэлт, нотлох баримтыг үндэслэн байгууллагын даргын 2020 оны А/17 тоот тушаалаар хуримтлагдсан өр төлбөрийг хассанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 171,044.9 мянган төгрөг болж 21,528.2 мянган төгрөгөөр өссөн нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 35,018.3 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотойгоор багшийн мэргэжил дээшлүүлэх зардлын санхүүжилт буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 51,807.0 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг зардлууд буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 168.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь эзэн холбогдогч тодорхойгүй, дансны бичилтийн алдаанаас үүссэн 916.1 мянган төгрөгийн авлага, 1,084.8 мянган төгрөгийн өр төлбөрийг ажлын хэсгийн шийдвэр, нотлох баримтад үндэслэн байгууллагын даргын тушаалаар залруулга хийснээс шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2020 оны төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "71801" сургуулийн өмнөх боловсрол, "71802" ерөнхий боловсрол гэсэн 2 хөтөлбөрийн хүрээнд "80802-ажил олгогчоос олгох тэтгэмж" гэсэн 1, "71808" Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрийн

“80101-үндсэн үйл ажиллагааны зардал”, “80802-ажил олгогчоос олгох тэтгэмж” гэсэн 2 нийт 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 526,535.6 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 526,390.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 511,377.9 мянган төгрөгийг зарцуулж, 15,012.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 511,377.9 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил зардлыг 286.4 мянга, ажил олгогчоос төлөх НДШ зардлыг 1,175.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 8.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 50.4 мянга, урсгал шилжүүлэг зардлыг 13,631.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 1, 71802 хөтөлбөрийн 1, 71808 хөтөлбөрийн 2 арга хэмжээ хэрэгжсэн боловч 15,012.5 мянган төгрөгөөр хэмнэгдэж зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

“Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-т орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2019 оны буцаан төвлөрүүлсэн орлого 2,975.8 мянга, ЕБС-ийн тэтгэлэг хөтөлбөрийн санхүүжилт 743.0 мянга, БСШУЯ-ны багшийн мэргэжил дээшлүүлэх зардлын санхүүжилт 3,592.0 мянга, хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 1,917.5 мянга, аймгийн ЗДТГ-аас 1,620.0 мянга, нийт 10,848.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс сургалтын зардалд 4,857.4 мянга, томилолт, шатахуун, бичиг хэргийн зардалд 743.0 мянга, тэмцээний зардалд 1,620.0 мянга, хүүхэд харах үйлчилгээний зардалд 1,017.0 мянга, бусад зардалд 1,616.0 мянга, нийт 9,853.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 994.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл байгаа ба 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 88,195.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 61,275.4 мянган төгрөгийн 11 алдааг залруулж, 2,764.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 2,666.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага,

21,489.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 4 | 2,764.9 | 4 | 2,764.9 | - | - | - |
| Албан шаардлага | 2 | 2,666.2 | 2 | 2,666.2 | - | - | - |
| Зөвлөмж | 5 | 21,489.0 | 5 | 21,489.0 | - | - | - |
| **Нийт дүн** | **11** | **26,920.1** | **11** | **26,920.1** | **-** | **-** | **-** |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,383.2 мянган төгрөгийн 23 алдаа, зөрчил илэрснээс, 46,255.2 мянган төгрөгийн 15 алдааг залруулж, 524.6 мянган төгрөгийн 4 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,603.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг аудитын явцад санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, он дамжин хуримтлагдан үүссэн 271.7 мянган төгрөгийн өр, авлагыг хаахдаа найдваргүй авлага зардлаар бүртгэсэн байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж залруулсан.
2. НДШ-ийн тайланд ажилчдад олгосон цалинг 100.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
3. 2 ажилтанд цалингийн зөрүү олгохдоо шууд гарт олгох цалинг 400.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
4. 1 ажилтанд цалин, ээлжийн амралтыг 73.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
5. 1 ажилтанд зэрэг дэвийн нэмэгдлийг дутуу, 1 ажилтанд ажил хавсарсны нэмэгдлийг илүү олгосон нийт 345.1 мянган төгрөгийг зөрүүтэй олгосон байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
6. Тайлант хугацаанд цалинтай холбоотой 10,368.9 мянган төгрөгийн өглөг, авлага үүссэнийг барагдуулж ажиллаагүй байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
7. Ажиллагчидтай холбогдсон цалингийн өглөгийг 169.7 мянган төгрөгийн хасах дүнгээр бүртгэсэн байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
8. Үнэ төлбөргүй өгсөн 237.6 мянган төгрөгийн номыг бичиг хэргийн материал дансанд бүртгэсэн байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
9. Тооцооны дансаар дамжуулаагүй 2,767.6 мянган төгрөгийн гүйлгээ бүртгэсэн байсныг залруулав.

10. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, ахмадын сан, төвлөрүүлэх шилжүүлгийн 2,622.4 мянган төгрөгийн тохиргоо бичилт хийгээгүй байсныг залрууллав.
11. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 2,800.0 мянган төгрөгөөр дутуу бодсон байсныг залруулав.
12. Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 18,426.3 мянган төгрөгийн орлогыг худалдан авсан дансанд тайлагнасан байсныг залруулав.
13. Няравын тайлан нягтлан бодогчийн хянасан тайлангаас 685.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулав.
14. Хөрөнгө худалдан авсан 1,443.2 мянган төгрөгийн зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй байсныг залруулав.
15. Нэмэлт санхүүжилтийн орлогыг 5,544.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг залруулав.

## Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2,128.0 мянган төгрөгийн залруулагдаагүй 6 алдаа, зөрчил илэрснээс 524.6 мянган төгрөгийн 4 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Автомашины норм нормативыг хэтрүүлж, 197.8 мянган төгрөгийн шатахууны зардал зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй 119.0 мянган төгрөгийн сургалтын зардал зарцуулсан, ахмадын сангаас зардал зарцуулахдаа 35.0 мянган төгрөгийн суутгасан татварыг шилжүүлээгүй нийт 351.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20 дугаар зүйлийн 20.2.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 347 дугаар тушаал, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" дахь заалттай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон \илүү 115.1, дутуу 57.8 мянга/ нийт 172.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй байна.

   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.6, Сангийн сайдын 347 дугаар тушаал дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ /7 удаагийн зарлагын гүйлгээ /, санхүүгийн тайлан хагас жилээр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.4.5, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалт, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</u>

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,603.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

“Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын санхүүгийн үйл ажиллагаанд нарийвчлан авах үзэх асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:* Нэмэлт санхүүжилтийн 1,603.4 мянган төгрөгийн зардлыг дансны ангилал зөрчиж гүйлгээ хийсэн байна.

*1.2. Эрсдэл:* Төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

*1.3. Өгсөн зөвлөмж:* Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам", үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг дансны ангилал бүрээр нээлгэх

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвшөөрсөн

***2. Дотоод хяналттай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүй байна.

*2.2. Эрсдэл:* Хяналтгүй гүйлгээ хийгдэх, татвараас зайлсхийх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Сангийн сайдын 347 дугаар тушаал, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн дотоод хяналтын журам боловсруулж, хэрэгжүүлэх, татварын цахим бүртгэлийн системээр зарцуулалтыг хянаж байх

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

2021.02.05

***Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл урлагийн газар"-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

ГСА-2021/45/СТА-ТШ3

**Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"**

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, он дамжин хуримтлагдан үүссэн өр, авлагыг хаахдаа найдваргүй авлага зардлаар бүртгэсэн | 271.7 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 2 | НДШ-ийн тайланд ажилчдад олгосон цалинг дутуу тайлагнасан | 100.0 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 3 | 2 ажилтанд цалингийн зөрүү олгохдоо шууд гарт олгох цалинг нэмэгдүүлсэн | 400.0 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 4 | 1 ажилтанд цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон | 73.0 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 5 | 1 ажилтанд зэрэг дэвийн нэмэгдлийг дутуу, 1 ажилтанд ажил хавсарсны нэмэгдлийг илүү олгосон | 345.1 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 6 | Тайлант хугацаанд цалинтай холбоотой их хэмжээний өглөг, авлага үүссэнийг барагдуулж ажиллаагүй | 10,368.9 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 7 | Ажиллагчидтай холбогдсон цалингийн өглөгийг хасах дүнгээр бүртгэсэн | 169.7 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 8 | Үнэ төлбөргүй өгсөн номыг бичиг хэргийн материал дансанд бүртгэсэн | 237.6 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 9 | Тооцооны дансаар дамжуулаагүй гүйлгээ бүртгэсэн | 2,767.6 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 10 | Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, ахмадын сан, төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгээгүй | 2,622.4 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 11 | Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодсон | 2,800.0 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг худалдан авсан дансанд тайлагнасан | 18,426.3 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 13 | Няравын тайлан нягтлан бодогчийн хянасан тайлантай таараагүй | 685.4 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 14 | Хөрөнгө худалдан авсан зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй | 1,443.2 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 15 | Нэмэлт санхүүжилтийн орлогыг дутуу тайлагнасан | 5,544.2 | Залруулах | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 16 | Автомашины норм нормативыг хэтрүүлж, шатахууны зардал зарцуулсан | 197.8 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 17 | Анхан шатны баримтын бүрдэлгүй сургалтын зардал зарцуулсан | 119.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 18 | Ахмадын сангаас зардал зарцуулахдаа суутгасан татварыг шилжүүлээгүй | 35.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 19 | ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон \илүү 115062, дутуу 57802 \ | 172.8 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 20 | Нэмэлт санхүүжилтийн зардлыг дансны ангилал зөрчиж гүйлгээ хийсэн | 1,603.4 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 21 | Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг хянаж тулгаагүй | - | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 22 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлан хагас жилээр дутуу мэдээлсэн /7 удаагийн зарлагын гүйлгээ / | - | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 23 | Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй, | - | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| **ДҮН** | | **48,383.2** | | | |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2021 оны 02 сарын 22 өдөр Дугаар 01/11 Чойр

Төлбөр барагдуулах тухай

**Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын** 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Автомашины норм нормативыг хэтрүүлж, 197.8 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан,
2. **Анхан шатны баримтын бүрдэлгүй 119.0 мянган төгрөгийн сургалтын зардал** зарцуулсан,
3. Ахмадын сангаас зардал зарцуулахдаа 35.0 мянган төгрөгийн суутгасан татварыг шилжүүлээгүй нийт 351.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", **13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,** санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, **байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар** зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан **"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай** тус тус нийцэхгүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.5-т бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.6-т "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан", 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

0800000293

1. Норм нормативаас хэтрүүлсэн болон анхан шатны баримтгүй зарцуулсан, татвар суутган тооцоогүй нийт 351,800.00 төгрөгийг барагдуулж, орон нутгийн орлогын “Төсөвт байгууллагын өөрийн орлого” 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга А.Зургаанжин, нягтлан бодогч Н.Одонтуяа нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Б.АНХТУЯА

A217144454
CA0055 9019043

---

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2021 оны 02 сарын 22 өдөр Дугаар 02/12 Чойр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон \илүү 115.1, дутуу 57.8 мянга\ нийт 172.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “5.1.4.үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-т “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т *“Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”*, 4.2.3.5-т бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон 115,062.00 төгрөгийг барагдуулж, Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын “Төсөвт байгууллагын өөрийн орлого” 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх, хавсралтын дагуу 57,802.00 төгрөгийг буцаан олгох
2. Актын биелэлтийг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга А.Зургаанжин, нягтлан бодогч Н.Одонтуяа нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Б.АНХТУЯА

4217144454
УСА0055 9019049

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

0800000204

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
2021 оны 02/12 дугаартай төлбөрийн актын хавсралт

"Боловсрол, соёл, урлагийн газар"-ын төлбөрийн актын жагсаалт

| Д/Д | Албан тушаалтны нэр | Актын дүн | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | А.Зургаанжин | 68,578.00 | Суутгах |
| 2 | Б.Энхмэнд | 36,856.00 | Буцаан олгох |
| 3 | С.Энх-Амгалан | 46,484.00 | Суутгах |
| 4 | Б.Гарамсан | 20,946.00 | Буцаан олгох |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 22 өдөр Дугаар 01/15 Чойр

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. **Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 7 удаагийн зарлагын гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй, хяналт тавьж ажиллаагүй байна.**

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-т “өөрийн хянах цэсний мэдээллийг байнга хянах” гэж заасныг тус тус **хэрэгжүүлж ажиллаагүй** байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”*, 4.2.1.11-д *“хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 7 удаагийн зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлан хагас жилээр дутуу мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;

---

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

0860000347

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга А.Зургаанжин, нягтлан бодогч Н.Одонтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Б.АНХТУЯА

4217144454
УСА0055 9019049

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
2021 оны 01/15 дугаартай албан шаардлагын хавсралт

4217144454
УСА0055 9019043

"Боловсрол, соёл, урлагийн газар"-ын албан шаардлагын жагсаалт

| Д/Д | Мэдээлээгүй зөрчлийн утга | Мэдээлээгүй тушаал шийдвэрийн дугаар, орлого, зарлагын он сар өдөр |
|---|---|---|
| 1 | Таван сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад зарлагын гүйлгээ | 2020.09.16-4 гүйлгээ, 2020.09.29, 2020.11.10, 2020.12.10 |
| 2 | Санхүүгийн тайлан | Хагас жилээр |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 22 өдөр Дугаар 02/16 Чойр

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Боловсрол, соёл, урлагийн газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт БМ-7, БМ-8" гэж заасныг тус тус **хэрэгжүүлж ажиллаагүй** байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.*", 4.2.1.2-д "*хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга А.Зургаанжин, нягтлан бодогч Н.Одонтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Б.АНХТУЯА

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

CA0055 90190

0860000348

[redacted]

**Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл**

[redacted]

**B501**

[redacted]

**ГСА/2021/45/СТА-ТШЗ**

**Төгрөгөөр**

[redacted]

**Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан**

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу тайлбар | Гаргасан шийдвэр | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах ажилтан: Албан тушаал | Овог нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Өглөг, авлага | 1 | Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, он дамжин хуримтлагдан үүссэн өр, авлагыг хаахдаа найдваргүй авлага зардлаар бүртгэсэн | 271,690.00 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 2 | Цалин | 1 | НДШ-ийн тайланд ажилчдад олгосон цалинг дутуу тайлагнасан | 100,000.00 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 3 | Цалин | 1 | 2 ажилтанд цалингийн зөрүү олгохдоо шууд гарт олгох цалинг нэмэгдүүлсэн | 400,000.00 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 4 | Цалин | 1 | 1 ажилтанд цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон | 72,990.00 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 5 | Цалин | 1 | 1 ажилтанд зэрэг дэвийн нэмэгдлийг дутуу, 1 ажилтанд ажил хавсарсны нэмэгдлийг илүү олгосон | 345,128.38 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 6 | Өглөг, авлага | 1 | Тайлант хугацаанд цалинтай холбоотой их хэмжээний өглөг, авлага үүссэнийг барагдуулж ажиллаагүй | 10,368,979.50 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 7 | Өглөг, авлага | 1 | Ажиллагчидтай холбогдсон цалингийн өглөгийг хасах дүнгээр бүртгэсэн | 169,658.43 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 8 | Бараа материал | 1 | Үнэ төлбөргүй өгсөн номыг бичиг хэргийн материал дансанд бүртгэсэн | 237,598.00 | Завсрын аудитаар зөвлөмж өгсөн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | Зөвлөмжийг хэрэгжүүлсэн | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 9 | Орлого, үр дүн | 1 | Тооцооны дансаар дамжуулаагүй гүйлгээ бүртгэсэн | 2,767,600.00 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 10 | Төсвийн гүйцэтгэл | 1 | Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, ахмадын сан, төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгээгүй | 2,622,400.00 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 11 | Үндсэн хөрөнгө | 1 | Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодсон | 2,800,000.02 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 12 | Бараа материал | 1 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг худалдан авсан дансанд тайлагнасан | 18,426,302.66 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 13 | Бараа материал | 1 | Няравын тайлан нягтлан бодогчийн хянасан тайлантай тааралгүй | 685,392.00 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 14 | Мөнгөн гүйлгээ | 1 | Хөрөнгө худалдан авсан зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй | 1,443,200.00 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 15 | Төсвийн гүйцэтгэл | 1 | Нэмэлт санхүүжилтийн орлогыг дутуу тайлагнасан | 5,544,222.05 | Залруулга хийх | Аудитын явцад залруулсан. | Аудитын явцад залруулсан. | | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 16 | Зардал | 1 | Автомашины норм нормативыг хэтрүүлж, шатахууны зардал зарцуулсан | 197,800.00 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 17 | Зардал | 1 | Анхан шатны баримтын бүрдэлгүй сургалтын зардал зарцуулсан | 119,000.00 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 18 | Зардал | 1 | Ахмадын сангаас зардал зарцуулахдаа суутгасан татварыг шилжүүлээгүй | 35,000.00 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 19 | Цалин | 1 | ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон \илүү 115062, дутуу 57802 \ | 172,864.00 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Зардал | 1 | Нэмэлт санхүүжилтийн зардлыг дансны ангилал зөрчиж гүйлгээ хийсэн | 1,603,400.00 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 21 | Дотоод хяналт | 1 | Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг хянаж тулгаагүй | - | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 22 | Шилэн данс | 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлан хагас жилээр дутуу мэдээлсэн /7 удаагийн зарлагын гүйлгээ / | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| 23 | Үндсэн хөрөнгө, бараа материал | 1 | Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй, | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | А.Зургаанжин, Н.Одонтуяа |
| | | | **Нийт дүн** | **48,383,225.04** | | | | | | |

**Бэлтгэсэн:**

Аудитор / Б.Анхтуяа / 2021.02.03

**Ахлах шатанд хянасан:**

Аудитын менежер / Г.Наранбаяр / 2021.02.03

**Хоёр дахь шатанд хянасан:**

Тэргүүлэх аудитор / Б.Сарантуяа / 2021.02.08

**Танилцаж зөвшөөрсөн:**

Говьсүмбэр аймгийн БСУГ-ын дарга /А.Зургаанжин / 2021.02.03

Төсвийн мэргэжилтэн, нягтлан бодогч / Н.Одонтуяа / 2021.02.03